

101



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 91

Номгон

Автомашин балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2020 онд ашиглалтад орсон 52,0 (Тавин хоёр) сая төгрөгийн өртөг бүхий Мал угаалгын автомашиныг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн автомашиныг комисс томилж актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшигч байгууллагын нэр дээр шилжүүлж, автомашиныг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор бодит үнэ цэнэ, цаашид ашиглах хугацааг тогтоож үндсэн хөрөнгөд бүртгэхийг “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал (Т.Отгонбаатар)-д үүрэг болгосугай.

4. Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал (Т.Отгонбаатар) нарт ДААЛГАХ нь:

4.1. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

4.2. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2021 оны 08 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

0121176

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

